

## “УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА ЗУД”

Гэрэл зургийн уралдаан

---

### Уралдааны зорилго:

Жил өнгөрөх тусам уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгалийн гамшгийн давтамж ихэсч, нөхцөл байдал нь улам хүндэрч байгаагаас шалтгаалан ард иргэд, ялангуяа хөдөө орон нутгийн малчид, эмэгтэйчүүд болон хүүхдүүд хамгийн ихээр өртөж байгаа билээ. Монгол улс нь байгалийн аюулт үзэгдлийн нөлөөнд өртөмтгий байдлаараа дэлхийд дээгүүр жагсдаг бөгөөд энэ нь манай орны бэлчээрийн мал аж ахуйн онцлог, бэлчээрийн доройтол ба даац хэтрэлт, малчдын эдийн засгийн чадамж зэрэг олон хүчин зүйлээс улбаатай. Манай байгууллага энэ сэдвийн хүрээнд мэдээллийн кампанит ажил явуулахаар төлөвлөж байгаа бөгөөд энэхүү гэрэл зургийн уралдаанд шалгарсан бүтээлүүдээр дамжуулан олон нийтийн анхаарлыг татах, ойлголтыг нэмэгдүүлэх, хөндөж буй асуудлаар сэдэлжүүлэх зорилготой.

### Мэдээлэл:

Уралдаанд дээрх сэдвийн хүрээнд бүтээлүүдийг хүлээн авах ба гэрэл зургийн төрөлд бүтээл туурвидаг мэргэжлийн болон сонирхогчид зэрэг бүхий л уран бүтээлчдэд нээлттэй.

Уралдаанд оролцох гэрэл зургийн бүтээлийг **2024.10.08 - 2024.10.22**-ны 18 цаг хүртэл НҮБ-ын байранд файл хэлбэрээр болон дээр дурдсан хугацаанд [menkhtuvshin@iom.int](mailto:menkhtuvshin@iom.int) цахим хаягаар хүлээн авна.

Бүтээлээ ирүүлэхдээ уран бүтээлч нь өөрийн овог нэр, утасны дугаар, цахим хаяг болон бүтээлийн нэр, агуулга, санааг илэрхийлсэн дэлгэрэнгүй мэдээллийг хамтад нь ирүүлнэ. Мэдээлэл дутуу бол бүтээлийг хүлээн авахгүйг анхаарна уу.

### Уралдааны шилдэг бүтээлийн шагнал:

- 1-р байранд 1 бүтээл – Өргөмжлөл / 1.000.000 төгрөг /
- 2-р байранд 1 бүтээл – Өргөмжлөл / 700.000 төгрөг /
- 3-р байранд 1 бүтээл – Өргөмжлөл / 300.000 төгрөг /

### Ерөнхий зохион байгуулагчид:

Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын “Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шилжилт хөдөлгөөнийг зохицуулах нь” төслийн хүрээнд зохион байгуулж байгаа болно.

### Зохион байгуулагчидтай холбогдох:

Харилцах утас: 99121321, 85114303